



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 01/2016

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/257 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан гэнэтийн хүчин зүйлийн зардлаас Спортын төв ордны тохижилтын зардалд 50,000,000 төгрөг /тавин сая/-ийг Биеийн тамир, спортын хөгжлийн төвд, Нийслэлийн налайх дүүрэгт баригдаж буй олон улсын стандартын хөнгөн атлетикийн тартанан замыг суурилуулах ажлын үйлдэгдэл санхүүжилтийг 200,000,000 сая төгрөг /хоёр зуун сая/-ийг Налайх дүүргийн Засаг даргын тамгын газарт тус тус эрх шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажиллахыг Биеийн тамир, спортын хөгжлийн төв /Д.Жаргалсайхан/-д, Нийслэлийн Налайх дүүргийн Засаг дарга /Х.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратеги бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-д даалгасугай.

• САЙД



С.ЛАМБАА

080960